

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХҮН АМЫН ҮЗҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВ, 2019 ОНД**



**АРВАЙХЭЭР
2019 ОН**

АГУУЛГА

БҮЛЭГ 1. ЕРӨНХИЙ ХАНДЛАГА

1.1 Хүн амын тооны өсөлт, өөрчлөлт

1.2 Хот, хөдөөгийн хүн амын харьцаа

1.3 Нийт өрхийн тоо, нэг өрхөд ногдох хүн

1.4 Хүн амын нас, хүйсийн бүтэц

БҮЛЭГ 2. ХҮН АМЫН ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨН

2.1 Төрөлт

2.2 Нас баралт

2.3 Гэрлэлт, цуцлалт, үрчлэлт

БҮЛЭГ 3. ХҮН АМЫН ДОТООД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

3.1 Хүн амын дотоод шилжих хөдөлгөөний өнөөгийн байдал

3.2 Шилжин ирэлт

3.3 Шилжин явалт

3.4 Хүн амын цэвэр шилжих хөдөлгөөн


БҮЛЭГ 4. ДҮГНЭЛТ

БҮЛЭГ 1. ЕРӨНХИЙ ХАНДЛАГА

1.1 Хүн амын тооны өсөлт, өөрчлөлт

Өвөрхангай аймгийн хүн амын тоо 2019 оны жилийн эцсийн байдлаар 116.7 мянга болж, өмнөх оныхоос 87 хүн буюу 0.1 хувиар өссөн бол 2006 оныхоос 7.2 мян.хүн буюу 7.7 хувиар, 2008 оныхоос 6.2 мян.хүн буюу 5.6 хувиар тус тус өссөн байна. Хүн амын тоо 2006 оноос хойш өссөн хэдий ч өсөлтийн хурд тогтвортой байсангүй. Тухайлбал, хүн амын өсөлтийн хурд 2007-2009 хүртэл аажим өсч байснаа 2010-2011 оноос тогтмол болж, 2012 оноос буурч 2013-2019 хүртэл аажмаар өссөн байна.

ЗУРАГ 1.1. ХҮН АМЫН ДУНДАЖ ӨСӨЛТИЙН ХУВЬ 2006-2019 ОН



Хүн амын өсөлтөд төрөлт, нас баралт, гадаад шилжих хөдөлгөөн гэсэн хүн ам зүйн үндсэн гурван үзүүлэлт шууд нөлөөлдөг.

Сумдын хүн амын өсөлт, бууралтад хүн амын ердийн өсөлтөөс илүү механик өсөлтийн нөлөөлөл их хэвээр байна. Аймгийн төв болон УБ хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөний урсгал их байгаа нь аймаг нийслэлийн хүн ам жил ирэх тусам хурдтай өсөх нөхцөлийг үүсгэж байна.

Аймгийн нийт хүн амын 49.8 хувь нь эрэгтэйчүүд, 50.2 хувь нь эмэгтэйчүүд байна. Хүйсийн харьцаа буюу 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоо 99.2 байна.

ЗУРАГ 1.2. ЭРЭГТЭЙ, ЭМЭГТЭЙ ХҮН АМЫН ХУВИЙН ЖИН 2019 ОН



1.2 Хот, хөдөөгийн хүн амын харьцаа

2019 оны эцсийн байдлаар аймгийн нийт нутаг дэвсгэрт оршин суугаа хүн амын 52.0 хувь буюу 60.2 мянга нь сумын төвд, 48.0 хувь буюу 55.4 мянга нь хөдөөд амьдарч байна. 2009-2019 онд дунджаар, нийт хүн амын 52.9 хувь нь сумын төвд 47.1 хувь нь хөдөөд амьдарч байна.


ХҮСНЭГТ 1.1. ХОТ, ХӨДӨӨГИЙН ХҮН АМЫН ТОО, СУМААР 2014-2019 ОН

	2014		2015		2016		2017		2018		2019	
	Сумын төв	Хөдөө	Сумын төв	Хөдөө	Сумын төв	Хөдөө	Сумын төв	Хөдөө	Сумын төв	Хөдөө	Сумын төв	Хөдөө
Бүгд	65013	47578	63264	49510	56867	57044	64310	51374	60627	53018	60286	55451
Баян - Өндөр	1089	2782	1045	2773	1047	2763	749	3067	1049	2675	1031	2620
Бүрд	854	1989	750	2117	461	2445	767	2184	469	2482	459	2439
Бат - Өлзий	4634	2567	3871	3363	2731	4641	4374	3125	2851	4746	2800	4785
ББ- Улаан	1096	1563	1094	1628	1036	1737	963	1840	777	2036	651	2135
Баянгол	954	2853	926	2896	677	3202	1018	2921	672	3273	624	3206
Гүчин - Ус	761	1399	889	1272	496	1691	676	1519	485	1724	482	1712
Есөнзүйл	978	2094	775	2248	780	2294	916	2199	745	2289	709	2199
Өлзийт	625	1866	625	1830	735	1696	1002	1444	751	1723	725	1668
ЗБ - Улаан	1225	2780	1242	2703	675	3351	823	3243	922	3106	886	2961
Богд	1205	4151	1060	4314	848	4700	1583	4043	807	4847	781	4911
Нарийнтээл	1005	2563	1247	2301	1299	2266	831	2832	1127	2541	1092	2479
Сант	1194	2500	913	2638	668	2901	781	2863	666	2942	638	2932
Тарагт	1186	1994	1195	2025	1235	2088	806	2567	1187	2151	1117	2028
Төгрөг	1020	1650	1158	1493	787	1948	1126	1638	769	1994	713	2001
Уянга	4230	5104	4044	5385	2863	6622	5020	4492	2815	6800	2717	6803
Хайрхандулаан	1289	2052	1330	2027	711	2759	888	2630	712	2809	673	2806
Хужирт	3442	3094	3182	3448	2823	3837	3609	3142	2866	991	2825	3948
Хархорин	9878	2665	9439	2826	8714	3691	8958	3558	8610	3889	8472	3818
Арвайхээр	28348	1912	28479	2223	28281	2412	29420	2067	32347	-	32891	-

Сүүлийн жилүүдийн хот, хөдөөгийн хүн амын өсөлтийн чиг хандлагыг харахад нийт дүнд эзлэх сумын төвийн хүн амын хувийн жин нэмэгдэж,

хөдөөгийн хүн амын хувийн жин буурах төлөвтэй байна. Сумын төвийн өрх өсч байгаа нь аймгийн дотоод шилжих хөдөлгөөний урсгал гол төлөв төв, суурин газар руу чиглэж байгаатай холбоотой юм. Нэг хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэрт ногдох хүний тоо 2019 онд 1.8 болсон байна.

ЗУРАГ 1.2. ХҮН АМЫН НЯГТРАЛ, СУМААР, 2019 ОН



Сумаар авч үзвэл Арвайхээр сум нь нийт нутаг дэвсгэрийн дөнгөж 0.3 хувийг эзэлдэг хэрнээ хүн амын нягтралаар хамгийн өндөрт орж байна. 2019 оны байдлаар Арвайхээр сумын нэг хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэрт 187,5 хүн ногдож байгаа нь өмнөх оныхоос 2.5 хүнээр нэмэгджээ. Бусад сумдын хүн амын нягтралыг харахад газар нутгийн хэмжээ, хүн амын тооноосоо шалтгаалан харилцан адилгүй, тухайлбал Хархорин, Хужирт, Уянга, Бат-Өлзий зэрэг сумдууд бусдаас хамгийн өндөр, Баруунбаян-Улаан, Төгрөг, Богд, Гучин-Ус, Хайрхандулаан зэрэг сумдууд хамгийн бага буюу нэг хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэрт нэг хүрэхгүй хүн ногдож байна. Энэ нь мөн л хүн амын дотоод шилжих хөдөлгөөний урсгал төврүү чиглэсэн байгааг илэрхийлж байна.

1.3 Нийт өрхийн тоо, нэг өрхөд ногдох хүн

2019 онд нийт өрхийн тоо 33.0 мянга болж 2018 оныхоос 4.6 хувиар буурсан байна. Нийт өрхийн 23.8 хувь нь сумын төвд, 48.2 хувь нь хөдөөд амьдарч байна. Баянгол, Бүрд, Богд, Уянга, Хайрхандулаан, Зүүнбаян-улаан, Баруунбаян-улаан, Уянга зэрэг сумдын хөдөөгийн өрх нь сумын төвийн өрхүүдээс их байна.

Аймгийн дунджаар нэг өрхөд 3.4 хүн ногдож байгаа бөгөөд нэг өрхөд ногдох хүний тоогоор Баруунбаян-Улаан, Богд, Сант, Бүрд, Гучин-ус, Нарийнтээл, Баянгол, Хужирт, Хархорин, Арвайхээр зэрэг сумдууд аймгийн дунджаас өндөр буюу 3.5-3.9 хүн ногдож байгаа юм. (Хүснэгт 1.2).

ХҮСНЭГТ 1.3. ӨРХИЙН ТОО БОЛОН НЭГ ӨРХӨД НОГДОХ ХҮНИЙ ТОО, СУМААР 2013-2019 ОН


	2013	2014	2015	2016	2017	2018	2019	1 өрхийн дундаж ам бүл
Бүгд	32421	33015	33275	33540	34150	34652	33062	3.4
Баян-өндөр	1180	1169	1166	1159	1169	1165	1106	3.3
Бүрд	816	811	832	847	858	860	794	3.6
Бат-Өлзий	2169	2174	2186	2193	2229	2275	2225	3.4
ББ-Улаан	686	697	711	719	718	716	711	3.9
Баянгол	1114	1109	1128	1158	1174	1176	1079	3.5
Гучин-ус	589	596	609	623	637	647	613	3.5
Есөн-зүйл	907	900	914	909	929	934	858	3.4
Өлзийт	724	735	736	740	766	767	695	3.4
ЗБ-улаан	1188	1123	1238	1261	1302	1321	1212	3.1
Богд	1398	1412	1433	1447	1484	1507	1493	3.8
Нарийнтээл	984	1031	1024	1025	1060	1061	986	3.6
Сант	1001	1042	1023	1032	1041	1052	1020	3.5
Тарагт	994	1017	1050	1087	1094	1090	950	3.3
Төгрөг	797	793	798	820	824	826	809	3.3
Уянга	2657	2810	2828	2815	2834	2871	2775	3.4
Хайрхандулаан	1032	1052	1068	1106	1114	1114	1090	3.2
Хужирт	1920	1957	1937	1950	1992	2006	1910	3.5
Хархорин	3625	3729	3754	3785	3828	3869	3501	3.5
Арвайхээр	8640	8858	8840	8864	9097	9395	9235	3.6

1.4 Хүн амын нас, хүйсийн бүтэц

Хүн амын насны бүтцийг судлах нь тухайн улсын хүн ам зүйн түүхэн замналыг харах, одоогийн үйл явцыг үнэлж дүгнэх, цаашдын чиг хандлагыг тодорхойлох бололцоо олгодгоороо ихээхэн ач холбогдолтой юм. Ингэснээрээ хүн амын нас, хүйсийн бүтцийн өөрчлөлтийн чиг хандлагыг харгалзан улс орныхоо нийгэм, эдийн засгийн урт, богино хугацааны бодлого хөтөлбөр боловсруулах үндэслэл болдог.

Хүн амын төрөлт, нас баралтын түвшингээс хамааран тухайн улсын хүн амын насны бүтэц өөрчлөгдөж байдаг. Хүн амын хэдэн хувь нь хүүхэд залуучууд, идэр насныхан, эсвэл хөгшчүүд байгаагаас хамааран үе үеийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн хандлагад нөлөөлдөг. Тухайлбал, үйлдвэр уурхай, барилга, хөдөө аж ахуйн зэрэг салбарт ажиллах хүн хүчний нөөц хэр зэрэг байх, сургууль, эмнэлэг, үйлчилгээний байгууллагын хүчин чадал байршил ямар байх зэрэг нь хүн амын насны бүтцээс хамаарч зохицуулагддаг билээ. Нөгөө талаар хүн амын төрөлт, нас баралт, шилжих хөдөлгөөний чиг хандлага ч насны бүтцээс хамааралтай байдаг. Тухайлбал, хүн амын насны бүтэц идэрших хандлагатай болоход (хүн амд хөдөлмөрийн насны хүний эзлэх хувь нэмэгдэх үйл явц) цаашид хөдөлмөрийн насны эрэгтэй, эмэгтэй хүний онцлогийг харгалзан ямар төрлийн ажлын байрыг илүү хэрэгцээтэй болохыг тохируулах шаардлага гарна.

ЗУРАГ 1.4. ХҮН АМЫН НАСНЫ БҮТЭЦ, 2016-2019 ОН



2019 оны нийт хүн амыг насны бүлгээр авч үзвэл 31.2 хувийг 15 хүртэлх насны хүүхэд, 64.2 хувийг 15-64 насны хүн ам, 4.6 хувийг 65 ба түүнээс дээш насны өндөр настнууд эзэлж байна. Сүүлийн жилүүдэд хүн амын дунд хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувь буурч, өндөр настны эзлэх хувь өсч байгааг дээрх графикаас харж болно.

Нийт хүн амд хөдөлмөрийн насныхны эзлэх хувь өндөр байх үеийг “Хүн ам зүйн цонх” гэдэг. Энэ үед улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд хүн ам зүйн хүчин зүйл эергээр нөлөөлдөг. Хүн ам зүйн цонх нээгдсэн үед хүүхэд, залуучуудын боловсролын түвшинг дээшлүүлэх, мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэх урт удаан хугацааны бодлого хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэн, хөрөнгө оруулалт болон ажлын байрыг нэмэгдүүлсэн нөхцөлд ажиллах хүчний нөөц хүрэлцэхүйц байх нөхцөл бүрэлдсэн гэж ойлгож болох юм.

ХҮСНЭГТ 1.3. ХҮН АМЫН ТОО, ХҮН АМ ЗҮЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, СУМААР
2018, 2019 ОН

Сумын нэр	2018 он			2019 он		
	Хүн амын тоо	Хүн ам зүйн ачаалал	Хүйсийн харьцаа	Хүн амын тоо	Хүн ам зүйн ачаалал	Хүйсийн харьцаа
Бүгд	116645	54.6	98.9	115737	55.8	99.2
Баян - Өндөр	3724	54.6	101	3651	55.6	99.6
Бүрд	2951	56.1	105	2898	56.3	103.9
Бат - Өлзий	7597	55.5	99	7585	56.1	99.3
ББ- Улаан	2813	57.6	100	2786	57.0	99.2
Баянгол	3945	48.0	100	3830	48.6	100.7
Гучин - Ус	2209	51.1	99.7	2194	51.2	102.2
Есөнзүйл	3034	56.4	106	2908	57.6	107.1
Өлзийт	2474	56.7	103	2393	58.2	103.8
ЗБ - Улаан	4028	51.2	108	3847	51.9	107.9
Богд	5654	57.4	102	5692	58.7	102.2
Нарийнтээл	3668	48.9	103	3571	50.4	103.7
Сант	3608	51.5	103	3570	51.3	104.3
Тарагт	3338	48.2	106	3145	49.3	106.5
Төгрөг	2763	52.1	103	2714	51.5	103.2
Уянга	9615	52.8	99.9	9520	54.1	99.2
Хайрхандулаан	3521	49.4	104	3479	50.3	105.1
Хужирт	6857	56.8	102	6773	57.2	100.7
Хархорин	12499	54.7	99.5	12290	54.5	101.9
Арвайхээр	32347	57.6	91.7	32891	60.0	91.5

Өвөрхангай аймгийн хүн ам зүйн ачаалал 2019 онд хөдөлмөрийн насны 100 хүнд тэжээлгэгч 55.8 хүн ногдож байна. Амьдралд энэ үзүүлэлт тооцооноос нэлээд илүү байдаг. Тухайлбал, хөдөлмөрийн насанд байгаа үедээ 15-24 насныхан ихэнх нь боловсролоо ахиулах, мэргэжил эзэмшихээр суралцаж тэжээлгэгч байдаг. Мөн хөдөлмөрийн насанд байгаа боловч жирэмсэн, бага насны хүүхэд, өндөр настанг асран хамгаалагч, хөгжлийн бэрхшээлтэй, ажиллах чадваргүй, эсвэл ажилгүйчүүд гэх мэт тэжээлгэгчдийн тоо өсдөг.


2019 онд 15-64 насны хүн ам өмнөх оныхоос 1.5 хувиар буурсан нь хүн ам зүйн ачаалал өсөхөд нөлөөлсөн байна.

Сумдуудын хүн амын хүйсийн харьцааг харвал Баян-Өндөр, Бат-Өлзий, Баруунбаян-улаан, Уянга, Арвайхээр зэрэг сумдад 100 эмэгтэйд 91.5-99.6

эрэгтэй ногдож байна. Бусад сумдад 100 эмэгтэйд 100-с дээш эрэгтэй ногдож байна.

Хүн амын нас, хүйсийн суваргаас харахад, дунд хэсгээрээ аажмаар өргөсч байгаа нь хүн ам идэрших хандлагатай байгааг харуулж байна. 2019 онд 0-4 насны хүн амын тоо 5-9 насны хүн амын тооноос их, харин 10-14 насны хүн амын тоо бага байгаа нь 2002-2006 оны төрөлт бага байсныг харуулж байна.

ЗУРАГ 1.5. ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, 2019 ОН




2006 оноос эхлэн төрөлт нэмэгдэж эхэлсэн нь суваргаас харагдаж байна. Түүнчлэн 20-24 насны хүн ам харьцангуй их, ерөнхийдөө хөдөлмөрийн насны хүн ам нэмэгдэж, хүн ам зүйн цонхны үе үргэлжлэхийг суварга харуулж байна.

БҮЛЭГ 2. ХҮН АМЫН ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨН

Сүүлийн 10 гаруй жилийн хүн амын цэвэр өсөлт нь аймгийн хүн амын өсөлтөд нөлөө үзүүлсэн юм. Төрөлтийн ерөнхий коэффициент (ТЕК) 1990 оноос хойш эрчимтэй буурах хандлага ажиглагдаж 2004 онд 20.0, 2005 онд 19.4 болж буурч байсан хэдий ч 2006-2009 онд тогтмол өсч 2018 онд 22.8 болсон 2019 онд 25.9 болж өссөн байна. Нас баралтын ерөнхий коэффициент 2019 он 6.2 болж өмнөх оноос 0.2 хувиар буурсан байна.

ЗУРАГ 2.1. ТӨРӨЛТ, НАС БАРАЛТ, ЦЭВЭР ӨСӨЛТ 1000 ХҮНД
НОГДОХООР, 2007-2019 ОН



2.1 Төрөлт

1990 оноос хойшхи хүн амын төрөлтийн эрчимтэй бууралтанд нийгэм, эдийн засгийн шилжилтийн байдал, 1989 оны сүүлчээр үр хөндөлтийг чөлөөтэй болгосон, эмэгтэйчүүд жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн арга хэрэгслийг хэрэглэж төрөлтөө зохицуулах болсон, гэрлэлтийн нас хойшилсон, цөөхөн ам бүлтэй байх сонирхолтой болсон, эмэгтэйчүүдийн боловсролын түвшин дээшилсэн зэрэг олон хүчин зүйл нөлөөлсөн юм. Гэсэн хэдий ч 2006 оноос эхлэн төрөлтийн түвшин нэмэгдэж эхэлсэн нь 18 нас хүртэлх хүүхдийн мөнгөн тэтгэмж, шинэ төрсөн хүүхэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж эхэлсэнтэй холбоотой.

ЗУРАГ 2.2. ТӨРӨЛТИЙН ТОО, сүүлийн 10 жилд хамгийн их бага оноор



Төрөлтийн түвшин 2006-2009 онд нэмэгдэж, 1000 хүнд ногдох төрөлт 2009 онд 26.5 хүрч байснаа 2014 оноос буурах хандлага руу орж, 2017 онд 21.6 болж өмнөх оныхоос 2.0 пунктээр буурсан 2019 онд 25.9 болж өмнөх оныхоос 3.1 пунктээр өссөн байна. Төрсөн хүүхдийн тоо 2019 онд 2995 болж 2018 оныхоос 12.5 хувиар өссөн байна. Аймгийн төрөлтийн тоог сүүлийн 10 жилээр харвал 2019 онд хамгийн өндөр төрөлттэй, 2017 онд хамгийн бага төрөлтийн түвшинтэй байна.

Төрөлтийн тоог сумдаар харвал Арвайхээр сумын төрөлт бусад сумдаас их байгаа нь нийт төрөлтийн түвшний 27.6 хувийг эзэлж байна. Нийт амьд төрсөн хүүхдийн 72.4 хувь нь хөдөөд төрсөн байна.

ХҮСНЭГТ 2.1. ТӨРСӨН ХҮҮХЭД, ХҮЙСЭЭР, СУМААР

Сумдууд	2018 он төрсөн хүүхэд			2019 он төрсөн хүүхэд		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд	2662	1363	1299	2995	1550	1445
Баян - Өндөр	71	44	27	94	54	40
Бүрд	69	34	35	72	34	38
Бат - Өлзий	194	99	95	179	88	91
ББ- Улаан	69	29	40	77	40	37
Баянгол	84	44	40	100	48	52
Гүчин - Ус	44	22	22	63	41	22
Есөнзүйл	57	32	25	62	27	35
Өлзийт	57	27	30	58	31	27
ЗБ - Улаан	68	36	32	102	58	44
Богд	162	78	84	182	97	85
Нарийнтээл	84	49	35	98	47	51
Сант	63	32	31	94	51	43
Тарагт	74	43	31	88	48	40
Төгрөг	59	35	24	65	34	31
Уянга	228	116	112	269	136	133
Хайрхандулаан	66	29	37	92	53	39
Хужирт	192	90	102	149	83	66
Хархорин	225	118	107	324	153	171
Арвайхээр	796	406	390	827	427	400

2.2 Нас баралт

Хүн амын нас баралтын түвшин 2012 онд 1000 хүнд ногдох нас баралт 6.8, 2013 онд 6.2, 2014 онд 6.8 болж өсч байсан бол 2015 онд 6.3, 2016 онд 5.8 болж буурчээ. Энэ үзүүлэлт 2017 онд 6.0 болж өмнөх оныхоос 0.2 пунктээр өссөн, 2018 онд 6.4 болж өмнөх оныхоос 0.4 пунктээр өссөн бол 2019 онд 6.2 болж өмнөх оныхоос 0.9 пунктээр буурсан байна. Сүүлийн 10 жилээр нас баралтын түвшинг харьцуулбал 2018 онд хамгийн их буюу 753 хүрчээ.

ЗУРАГ 2.2. НАС БАРАЛТЫН ТОО , сүүлийн 10 жилд хамгийн их бага оноор

ХАМГИЙН
БАГА
2013

753

694

ХАМГИЙН
ИХ
2018

Нас барсан хүний тоог сумаар үзвэл Уянга, Хужирт, Хархорин, Арвайхээр сумдад хамгийн их байна. Мөн нас барсан хүний 28.8 хувь нь аймгийн төвд, 71.2 хувь нь хөдөө сумдад нас баржээ. Нас баралтын хүйсийн харьцаа буюу 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн нас баралтын тоог харвал аймгийн дундаж 171 байгаа нь эрэгтэйчүүд илүү нас барж байгаа нь дараах хүснэгтээс харагдаж байна.

ХҮСНЭГТ 2.2. НАС БАРСАН ХҮН, ХҮЙСЭЭР, СУМААР

Сумдууд	2018 он нас баралт			2019 он нас баралт		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд	753	442	311	717	453	264
Баян - Өндөр	27	18	9	20	13	7
Бүрд	17	11	6	20	15	5
Бат - Өлзий	35	17	18	34	20	14
ББ- Улаан	18	12	6	13	9	4
Баянгол	29	21	8	27	15	12
Гүчин - Ус	7	4	3	14	6	8
Есөнзүйл	22	13	9	21	12	9
Өлзийт	14	7	7	21	14	7
ЗБ - Улаан	27	16	11	22	16	6
Богд	42	26	16	34	20	14
Нарийнтээл	18	13	5	15	7	8
Сант	24	16	8	26	15	11
Тарагт	28	17	11	22	16	6
Төгрөг	13	6	7	12	9	3
Уянга	71	48	23	55	31	24
Хайрхандулаан	18	11	7	22	13	9
Хужирт	56	28	28	48	35	13
Хархорин	77	43	34	84	59	25
Арвайхээр	210	115	95	207	128	79

2.3 Гэрлэлт, цуцлалт, үрчлэлт

Нийт 545 хос 2019 онд гэрлэлтээ бүртгүүлж, 75 гэр бүл гэрлэлтээ цуцлуулж, 75 хүүхэд үрчлэгджээ. Гэрлэлт өмнөх оныхоос 97.1 хувиар буурч, үрчлэлт 29.3 хувиар өсч, гэр бүл цуцлалт 29.3 хувиар өссөн байна. 1000 хүнд ногдох гэрлэлт 2012 онд 1.5, 2013 онд 2.3, 2014 онд 3.5, 2015 онд 4.7, 2016 онд 4.1, 2017 онд 4.6 болж өмнөх оныхоос 0.5 пунктээр нэмэгдсэн 2018 онд 4.8 болж өмнөх оныхоос 0.2 пунктээр нэмэгдсэн 2019 онд 4.7 болж өмнөх оноос 0.1 пунктээр буурсан байна. Гэр бүл цуцлалт 2013 онд 0.9, 2014 онд 0.6, 2015 онд 0.6, 2016 онд 0.5,


2017 онд 0.5, 2018 онд 0.6, 2019 онд 0.6 байна. Гэрлэлтийн тоо нь 2006 онд хамгийн өндөр түвшинд буюу 2450-д хүрч байжээ.

ЗУРАГ 2.3. ГЭРЛЭЛТИЙН ТОО , сүүлийн 10 жилд хамгийн их бага оноор



1000 хүн амд ногдох гэрлэлт 2004 оноос өсөх хандлагатай болсон ба 2006 оноос эхлэн “Шинэ гэр бүл бологчид” хөтөлбөрийн хүрээнд шинээр гэр бүл бологчдод нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгож эхэлсэнтэй холбоотойгоор гэрлэлт нэмэгдэж 2006 онд 2450-д хүрсэн хэдий ч 2007-2012 онуудад тасралтгүй буурч байсан бол 2013 оноос өссөн байна.

ЗУРАГ 2.3. 1000 ХҮНД НОГДОХ ГЭРЛЭЛТ, ЦУЦЛАЛТ, 2009-2019 ОН



ЗУРАГ 2.3. ЦУЦЛАЛТЫН ТОО, сүүлийн 10 жилд хамгийн их бага оноор



2019 онд 75 хүүхэд үрчлэгдсэний 62.7 хувь нь 3 хүртэлх насны, 16.0 хувь нь 3-6 насны, 4.0 хувь нь 7-9 насны, үлдсэн 17.3 хувь нь 10 ба түүнээс дээш насны хүүхдүүд байна.

ХҮСНЭГТ 2.3. ХҮҮХЭД ҮРЧЛЭЛТ, НАСНЫ БҮЛГЭЭР, СУМААР 2019 ОН

Сумын нэр	Бүгд	Хүүхдийн насны бүлэг			
		3 хүртэлх настай	3-6 настай	7-9 настай	10, түүнээс дээш настай
Дүн	75	47	12	3	13
Баян-өндөр	2	1	1	-	-
Бүрд	-	-	-	-	-
Бат-Өлзий	5	4	-	1	-
ББ-Улаан	-	-	-	-	-
Баянгол	-	-	-	-	-
Гучин-ус	-	-	-	-	-
Есөн-зүйл	3	2	-	-	1
Өлзийт	1	1	-	-	-
ЗБ-улаан	1	1	-	-	-
Богд	2	1	-	-	1
Нарийнтээл	1	1	-	-	-
Сант	1	1	-	-	-
Тарагт	2	2	-	-	-
Төгрөг	3	2	-	1	-
Уянга	6	2	-	-	4
Хайрхандулаан	5	2	1	-	2
Хужирт	3	1	-	-	2
Хархорин	11	7	4	-	-
Арвайхээр	29	19	6	1	3

БҮЛЭГ 3. ХҮН АМЫН ДОТООД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

Хүн амын шилжих хөдөлгөөн нь төрөлт, нас баралтын нэг адил хүн амын өсөлт, өөрчлөлтийн нэг бүрэлдэхүүн хэсэг бөгөөд уугуул нутгийн хүн амын өөрчлөлтийг газар зүйн нэгжүүдээр тодорхойлж, хүн амын хөдөлгөөнийг судалдаг. Хүн амын зарим хөдөлгөөн нь түр зуурын байх буюу уугуул нутаг нь өөрчлөгдөхгүй байх тохиолдлыг шилжих хөдөлгөөнд тооцдоггүй. Иймд шилжих хөдөлгөөн нь тусгайлан тогтоосон засаг захиргааны болон газар зүйн нэгжүүдийн хооронд, түүнчлэн газар нутгийн байршлын /хот, хөдөө/ хувьд явагдах хүн амын суурьшлын өөрчлөлт юм.

Монгол Улсын “Иргэний бүртгэлийн тухай” хуулийн 25 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2002 оны 214 дүгээр тогтоолоор батлагдсан журамд “Иргэн байнга оршин сууж байгаа засаг захиргааны нэг нэгжээсээ нөгөөд 180 хоногоос дээш хугацаагаар оршин суухыг бүрмөсөн шилжин суурьших, 180 хоног ба түүнээс доош хугацаагаар оршин суухыг түр шилжин суурьших гэнэ” гэж тодорхойлсон байдаг.

Монгол Улсад хүн амын дотоод шилжих хөдөлгөөний асуудлыг Үндсэн хууль, Иргэний бүртгэлийн тухай, Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай болон бусад холбогдох хууль, түүнчлэн Засгийн газрын 2002 оны 214 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын нутаг дэвсгэрт иргэн шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх журам” зэрэг хууль тогтоомжоор зохицуулдаг. Дээрх эрх зүйн актуудаар хүн амын шилжих хөдөлгөөнийг зохицуулдаг ч аймагт шилжин суурьшигчдын нэлээд хэсэг нь журмын дагуу шилжиж суурьшаагүй, байнгын оршин суугчийн зөвшөөрөл, албан ёсны бүртгэлгүй хүмүүс байгаа юм.

3.1 Хүн амын дотоод шилжих хөдөлгөөний өнөөгийн байдал


2019 оны жилийн эцэст 619 хүн шилжин ирж, 1466 хүн шилжин явсан байна. Нийт шилжин ирсэн хүн амын 283 хүн буюу 45.7 хувь нь аймгийн төвд шилжин ирсэн байна. Мөн Бат-Өлзий суманд 51 хүн, Богд суманд 28, Бүрд суманд 27 хүн, Хархорин суманд 111 хүн шилжиж очсон байна. Шилжиж явсан хүн амын байдлаас харахад Хархорин сумаас 219, Арвайхээр сумаас 514, Богд сумаас 51 хүн, Уянга сумаас 87 хүн, Баян-өндөр сумаас 31 хүн, Батөлзий сумаас 73 хүн, Бүрд сумаас 55 хүн шилжин явсан нь бусад сумдаас өндөр байна.

ЗУРАГ 3.1. ХҮН АМЫН ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН, 2007-2019 ОН



3.2 Шилжин ирэлт

ЗУРАГ 3.2. ШИЛЖИН ИРЭЛТИЙН КОЭФФИЦИЕНТ, 2006-2019 ОН



Энэ үзүүлэлт нь 1000 хүнд ногдох шилжих хөдөлгөөнд оролцогчдын тоо бөгөөд 2006 онд 7.9, 2007 онд 5.3, 2008 онд 5.6, 2009 онд 4.9, 2010 онд 6.2, 2011 онд 3.3 болж буурсан бол 2012 онд 5.2, 2013 онд 7.1 болж өсчээ. 2014 онд 6.7, 2015 онд 7.5, 2016 онд 9.6, 2017 онд 9.3 болж, өмнөх оны мөн үеийнхээс 0.3 пунктээр буурсан 2018 онд 7.3 болж өмнө оныхоос 2.0 пунктээр буурсан 2019 онд 5.3 болж өмнөх оныхоос 2.0 пунктээр буурсан байна. (Зураг 3.2).


ХҮСНЭГТ 3.1. ШИЛЖИН ИРЭГЧИД, СУМААР 2008-2019 ОН

Сумын нэр	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019
Бүгд	624	553	698	373	579	793	760	849	1095	1078	855	619
Баян-өндөр			18	5	2	7	12	14	29	32		13
Бүрд	14	19	30	4	1	24	22	22	43	42	24	27
Бат-Өлзий	98	27	31	19	9	66	25	30	221	41	37	51
ББ-Улаан	5	17	3	2		7	7	6	27	15	7	6
Баянгол	4	3	4	1	2	7	4	23	20	16	32	15
Гучин-ус	8	9	2	1	8	3	8	19	7	11	13	4
Есөн-зүйл	15	12		7	8	20	22	16	17	42	6	16
Өлзийт	15	7	13	3	12	13	8	17	9	16	7	2
ЗБ-улаан	5	15	5	5	3	7	4	17	29	10	7	3
Богд	4	7	13	6	3	16	19	19	25	38	34	28
Нарийнтээл	7	20	24	5	9	13	24	20	19	32	12	4
Сант	15	10	26	2	5	4	6	12	15	23	22	9
Тарагт		4	9	11	3	4	6	22	17	16	8	3
Төгрөг	7	3	4	1	3	1	4	7	26	38	10	4
Уянга	42	30	31	20	9	13	34	43	45	31	29	15
Хайрхандулаан	7	15	12	9	2	7	10	21	5	13	9	9
Хужирт	69	23	66	23	23	36	37	20	34	60	31	16
Хархорин	111	52	131	39	52	222	153	122	138	208	85	111
Арвайхээр	198	262	289	213	420	318	353	384	366	389	473	283

3.3 Шилжин явалт

2019 оны жилийн эцэст 1466 хүн байнга оршин суудаг засаг захиргааныхаа нэгжээс шилжин явсан байна. Хүн ам зүйн судалгааны шилжих хөдөлгөөнтэй холбоотой чухал үзүүлэлтүүдийн нэг нь шилжин явалтын коэффициент юм. Энэ үзүүлэлт нь 1000 хүнд ногдох шилжин явагчдын тоо бөгөөд 2019 оны эцэст 1000 хүн тутмын 13 нь байнга оршин сууж байсан засаг захиргааны нэгжээсээ шилжин явсан нь 2006 оныхоос 4.7 пунктээр, 2007 оныхоос 7.3 пунктээр, 2008 оныхоос 7.0 пунктээр, 2009 оныхоос 7.7 пунктээр, 2010 оныхоос 6.4 пунктээр, 2011 оныхоос 9.3 пунктээр, 2017 оныхоос 4.3 пунктээр, 2018 оныхоос 2.9 пунктээр өссөн байна.

ЗУРАГ 3.3 ШИЛЖИН ЯВАЛТЫН КОЭФФИЦИЕНТ, 2006-2019 ОН



ХҮСНЭГТ 3.2. ШИЛЖИН ЯВАГЧИД, СУМААР, 2008-2019 ОН


Сумын нэр	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019
Бүгд	1378	1725	2309	3307	1974	3441	3108	2639	2362	968	1140	1466
Баян-өндөр	-	77	83	151	81	199	143	132	143	68	18	78
Бүрд	92	86	78	78	41	165	173	62	56	27	28	55
Бат-Өлзий	38	49	90	64	22	82	84	72	246	53	18	73
ББ-Улаан	26	38	23	40	29	47	41	43	15	18	31	38
Баянгол	3	6	10	32	61	44	22	80	48	26	17	28
Гучин-ус	21	26	64	18	22	67	30	41	18	6	11	13
Есөн-зүйл	78	67	-	112	72	159	114	115	74	24	24	50
Өлзийт	35	44	53	85	30	82	72	71	37	15	4	27
ЗБ-улаан	48	26	68	45	31	60	54	53	23	24	20	29
Богд	70	42	77	62	46	71	62	78	54	12	53	51
Нарийнтээл	31	33	73	40	37	99	89	55	77	22	17	29
Сант	35	70	105	98	65	98	135	88	67	37	15	32
Тарагт	12	58	5	52	10	52	28	57	5	7	16	15
Төгрөг	28	20	11	61	11	41	51	39	32	17	20	21
Уянга	63	87	107	102	147	183	204	162	104	36	42	87
Хайрхандулаан	21	34	50	44	41	48	60	49	29	12	11	30
Хужирт	141	136	161	197	115	231	238	94	118	60	29	77
Хархорин	38	214	271	359	247	646	526	467	389	169	85	219
Арвайхээр	598	612	980	1667	866	1067	982	881	827	335	681	514

Нийт шилжин явагчдын 35.0 хувь нь Арвайхээр, 14.9 хувь нь Хархорин, 5.9 хувь нь Уянга, 5.2 хувь нь Хужирт 4.9 Батөлзий сумаас шилжин явагчид эзэлж байна. (Хүснэгт 3.2).

3.4 Хүн амын цэвэр шилжих хөдөлгөөн

Шилжих хөдөлгөөний гол үзүүлэлт болох цэвэр шилжих хөдөлгөөний талаар энэ бүлэгт авч үзлээ. Шилжих хөдөлгөөний цэвэр коэффициент (ШХЦК) нь шилжин ирэлт болон шилжин явалтын коэффициентуудын ялгавраар илэрхийлэгдэнэ. ШХЦК нь 2006 онд -2.8 байсан бол 2013 онд -23.7, 2014 онд -20.9, 2015 онд -15.9, 2016 онд -11.1, 2017 онд 1.0, 2018 онд -2.4, 2019 онд -7.3 болсон байна.

ЗУРАГ 3.4. ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ ЦЭВЭР КОЭФФИЦИЕНТ, 2006-2019 ОН



Дотоод шилжих хөдөлгөөний хувьд ШХЦК нь 0 гарах ёстой байдаг хэдий ч иргэний бүртгэлийн явцад хугацааны зөрүүтэй байдлаас шалтгаалан энэ үзүүлэлт 0 гарах нь ховор байдаг. Эндээс үзэхэд 2019 онд шилжин явалт нь шилжин ирсэнээс их байна.

БҮЛЭГ 4. ДҮГНЭЛТ

Аймгийн хүн амын тоо 2019 оны жилийн эцсийн байдлаар 116.7 мянга болж, өмнөх оныхоос 87 хүн буюу 0.1 хувиар өслөө. Хүн амын 49.8 хувь нь эрэгтэйчүүд, 50.2 хувь нь эмэгтэйчүүд эзэлж байна. Хүйсийн харьцаа буюу 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоо 99.2 байна.

Аймгийн хэмжээнд 2019 оны байдлаар 33.0 мянган өрхийн, 23.8 хувь нь сумын төвд, 48.2 хувь нь хөдөөд байгаа бөгөөд аймгийн дунджаар нэг өрхөд 3.4 хүн ногдож байна.

Төрсөн хүүхдийн тоо 2019 онд 2995-д хүрч өмнөх оныхоос 12.5 хувиар өссөн байна. Аймгийн хүн амын төрөх үеийн хүйсийн харьцаа 100 охинд ойролцоогоор 107 хөвгүүн ногдож байна. Энэ онд 1000 хүнд ногдох нас баралт 6.4 болж, өмнөх оныхоос 0.4 пунктээр өсчээ.

Нийт 545 хос 2019 онд гэрлэлтээ бүртгүүлж, 75 гэр бүл гэрлэлтээ цуцлуулж, 75 хүүхдүүдийг үрчилж авчээ. Гэрлэлт өмнөх оныхоос 97.1 хувиар буурч, үрчлэлт 29.3 хувиар өсч, гэр бүл цуцлалт 29.3 хувиар өссөн байна. 1000 хүнд ногдох гэрлэлт 2012 онд 1.5, 2013 онд 2.3, 2014 онд 3.5, 2015 онд 4.7, 2016 онд 4.1, 2017 онд 4.6 болж өмнөх оныхоос 0.5 пунктээр нэмэгдсэн 2018 онд 4.8 болж өмнөх оныхоос 0.2 пунктээр нэмэгдсэн 2019 онд 4.7 болж өмнөх оноос 0.1 пунктээр буурсан байна. Гэр бүл цуцлалт 2013 онд 0.9, 2014 онд 0.6, 2015 онд 0.6, 2016 онд 0.5, 2017 онд 0.5, 2018 онд 0.6, 2019 онд 0.6 байна. Гэрлэлтийн тоо нь 2006 онд хамгийн өндөр түвшинд буюу 2450-д хүрч байсан бөгөөд энэ нь тэр үеийн шинэ гэр бүлд мөнгөн тэтгэмж олгохтой холбоотой нэмэгдэж байсан билээ.

2019 оны жилийн эцэст 619 хүн шилжин ирж, 1466 хүн шилжин явсан байна. Нийт шилжин ирсэн хүн амын 283 хүн буюу 45.7 хувь нь аймгийн төвд шилжин ирсэн байна. 1000 хүнд ногдох шилжих хөдөлгөөнд оролцогчдын тоо 2012 онд 5.2, 2013 онд 7.1 болж өсчээ. 2014 онд 6.7, 2015 онд 7.5, 2016 онд 9.6, 2017 онд 9.3 болж, 2018 онд 7.3 болж өмнө оныхоос 2.0 пунктээр буурсан бөгөөд 2019 онд 5.3 болж өмнөх оныхоос 2.0 пунктээр буурсан байна. 1000 хүнд ногдох шилжин явагчдын тоо 2019 оны эцэст 1000 хүн тутмын 13 нь байнга оршин сууж байсан засаг захиргааны нэгжээсээ шилжин явсан нь 2006 оныхоос 4.7 пунктээр, 2007 оныхоос 7.3 пунктээр, 2008 оныхоос 7.0 пунктээр, 2009 оныхоос 7.7 пунктээр, 2010 оныхоос 6.4 пунктээр, 2011 оныхоос 9.3 пунктээр, 2017 оныхоос 4.3 пунктээр, 2018 оныхоос 2.9 пунктээр өссөн байна.

Ашигласан ном зүй материал

1. Аймгийн 2019 оны нийгэм эдийн засгийн танилцуулга
2. Хүн ам орон сууцны тооллогын үр дүнгийн ном
3. www.1212.mn
4. www.uvurkhangai@nso.mn

ХЯНАСАН: ХЭЛТСИЙН ДАРГА О.ТҮМЭНЖАРГАЛ
ТАНИЛЦУУЛГА БЭЛТГЭСЭН : МЭРГЭЖИЛТЭН Д.ЧУЛУУНЦЭЦЭГ

Харилцах хаяг: Өвөрхангай аймаг, Арвайхээр сум, Нутгийн удирдлагын ордон,
403 тоот, утас 70323442

Имэйл: uvurkhangai@nso.mn, вэб хаяг: <http://uvurkhangai.nso.mn>